

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМ**

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**

ДУУССАН АЖЛЫН ТАЙЛАН

Сэдвийн нэр: Төрөлхийн хөгжлийн гажгийн давтамж, зонхилон тохиолдох
хэлбэрүүд, нөлөөлөх зарим хүчин зүйлс

Дэд сэдвийн удирдагч: Ш.Энхтөр АУ-ы доктор, клиникийн профессор,
ЭХЭМҮТ-ийн Ерөнхий захирал

Дэд сэдвийн зөвлөх: М.Баялаг АУ-ы доктор, ЭШСГХ эрхэлсэн дэд захирал

Гүйцэтгэгчид: Т.Гантуяа /ТСА-ны дарга/

Т.Номиндэлгэр /ТСА-ны их эмч/

П.Орхонтуул /ТСА-ны ажилтан/

Монгол оронд тохиолдох төрөлхийн хөгжлийн гажгийн давтамж, зонхилон тохиолдох хэлбэрүүд, нөлөөлөх зарим хүчин зүйлс

Т.Гантуяа, Т.Номиндэлгэр, П.Орхонтуул, М.Баялаг, Ш.Энхтөр
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Тодорхойлолт: Төрөх үед илэрч байгаа (бодисын солилцооны эмгэг зэрэг) бүтэц, үйл ажиллагааны гажгийг төрөлхийн хөгжлийн гажиг гэнэ¹.

Түүхэн баримтын талаар: МЭӨ 6500 оны үед анх төрөлхийн хөгжлийн гажгийн (ТХГ) талаар зарим баримтуудад үлдээсэн байдаг. Тухайлбал, 1962 онд Туркийн өмнөд хэсгээс Анатолигийн охин тэнгэр, нийлсэн ихрүүдийн баримал олдсон (МЭӨ 6500 оны) нь төрөлхийн хөгжлийн гажгийн эртний баримтын нэгд тооцогддог. Анх төрөлхийн хөгжлийн гажгийн талаар тэмдэглэн үлдээсэн бичмэл баримт болох 4000 жилийн настай, 62 төрлийн гажгийг дүрсэлсэн “Ниневийн хүснэгт”-ийг Вавилоны балгасаас олжээ.

Төрөлхийн альбинизмтай Ноа гэгч хүнийг түүний элэнц эцэг зөнч Энох дүрслэн бичсэн нь анхны төрөлхийн хөгжлийн гажигтай хүний талаарх баримт болсон байна. Улмаар ТХГ-ийн талаарх түүхэн баримтууд Перу, Мексик, Итали, Грек, Шри-Ланк, Австрали зэрэг алслагдсан газруудаас олдсон байна. Архины хэрэглээ, халдвар зэрэг нь төрөлхийн хөгжлийн гажгийн эрсдэлт хүчин зүйл болдог гэж эрт үеэс тэмдэглэн үлдээсэн төдийгүй хүүхдэд нөлөөлөх архины хор уршгийн талаар Библийн хуучин гэрээнд “Болгоогтун, чи хэвлийдээ үрээ тээж байгаа бол одоо дарс, хүчтэй ундаа ууж болохгүй” (Йудас 13:7) хэмээн дурьдсан байна. Европт тэмбүү өвчний тархалт өндөр байсан 15-р зууны сүүлээр халдвар буюу төрөлхийн тэмбүүгийн улмаас төрөлхийн хөгжлийн гажиг үүссэн гэх баримт анх тэмдэглэгджээ. 16-р зууны эхэн үеэс төрөлхийн тэмбүү өвчнийг төрөлхийн хөгжлийн гажгаас тусдаа зүйл гэж үзэх болжээ. Төрөлхийн хөгжлийн гажгийн өвөрмөц шалтгааныг 20-р зуунаас л таньж эхэлжээ².

Төрөлхийн хөгжлийн гажиг дэлхий дахинд: Дэлхий дээр 33 нялхас тутмын 1 төрөлхийн хөгжлийн гажигтай байдаг бол жил бүр 3.2 сая орчим нь төрөлхийн хөгжлийн гажгийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болдог хэмээжээ.

¹ <http://www.who.int/mediacentre/factsheets/fs370/en/>

² Global report on birth defects, March of Dimes Birth Defects Foundation, White Plains, New York, 2006

Жил бүр төрөлхийн хөгжлийн гажгийн улмаас 270000 нярай амьдралын эхний 28 хоног дотроо энддэг байна. 2010 онд 193 оронд эндсэн 3.08 сая нярайн эндэгдлийн шалтгааныг зураг 1-д дүрслэн харуулав.




Зураг 1. Нярайн эндэгдлийн шалтгаан, 2010 он

Төрөлхийн хөгжлийн гажгийн тохиолдол улс орон бүрт харилцан адилгүй байна. Солонгос, Индонез зэрэг орнуудад 500-600 амьд төрөлтөд 1, харин Европын орнуудад 1000-1500 амьд төрөлтөд 1 тохиолдол илэрдэг. 2006 оны байдлаар төрөлхийн хөгжлийн гажиг Тайланд, Африк бага Азийн орнуудад хамгийн өндөр тархалттай байна. Тухайлбал, 1000 амьд төрөлтөд ногдох тохиолдлын тоогоор Судан (82), Саудын Араб (81.3), Арабын Эмират (75.9), Ирак (75.2) зэрэг орнууд эхний байруудад орж байна³. Ийнхүү төрөлхийн хөгжлийн гажиг дэлхий нийтийн тулгамдсан асуудал болсон ба 95% орчим нь хөгжиж буй, ядуу буурай орнуудад тохиолдож байна. Төрөлхийн хөгжлийн гажиг хувь хүн, гэр бүл, эрүүл мэндийн тогтолцоо, нийгэмд сөрөг нөлөө үзүүлэх удаан хугацааны хөгжлийн бэрхшээлийг үүсгэдэг. Төрөлхийн хөгжлийн гажиг (ТХГ) нь перинатал эндэгдэл, өсөлт хөгжлийн хоцрогдол, дутуу төрөлт, өгзөг түрүүлэлт, жирэмсний хожуу хордлого, ихэс ховхролт, хүн амын хүйсийн харьцаа зэрэгт сөргөөр нөлөөлдөг¹.

Дэлхий дахинд перинатал ба нярайн эндэгдлийн голлох шалтгааны нэг нь төрөлхийн хөгжлийн гажиг² байна. Төрөлхийн хөгжлийн гажгийн тохиолдол бага, дунд орлоготой орнуудад 1000 амьд төрөлтөд 82, харин өндөр орлоготой орнуудад 39.7 байна³.

³ЭМЯ, ДЭМБ, ХӨСҮТ. "Mongolian field epidemiology training program" 2014; 31



Зураг 2. Нярайн эндэгдлийн шалтгаан, 2013 он, ДЭМБ

ТХГ нь олон хүчин зүйлээс шалтгаалж үүсэх ба нийт тохиолдлын 40 орчим хувьд нь шалтгаан тодорхойгүй хэмээн үздэг. Цусан төрлийн гэрлэлт, нийгэм-эдийн засгийн байдал, хүрээлэн буй орчноороо ялгаатай дэлхийн янз бүрийн хэсэгт, ястан, үндэстний дунд ТХГ-ийн тархвар зүйг судлах нь тухайн газрын гажгийн давтамжийг тогтоох төдийгүй нөлөөлөх хүчин зүйлс, ТХГ-ийн хэлбэрийг тогтоох, нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөхөд чухал ач холбогдолтой хэмээн үздэг. ТХГ-ийн хэлбэр, түвшин нь бүс нутгаас хамаарч ялгаатай байхаас гадна цаг хугацаанаас хамаарч янз бүр байна⁵. ДЭМБ-аас гаргасан судалгаагаар дэлхий нийтэд 2000 гаруй төрлийн ил, далд төрөлхийн хөгжлийн гажиг бүртгэгдэг байна. Нийт төрөлхийн хөгжлийн гажигтай нярайн 25% хавсарсан гажигтай байдаг. Хамгийн түгээмэл, хүнд хэлбэрийн төрөлхийн хөгжлийн гажигт зүрхний гажиг, мэдрэлийн тогтолцооны (гуурсны) гажиг, Дауны хам шинж ордог байна. Төрөлхийн хөгжлийн гажиг удамшил, халдвар, хүрээлэн буй орчны нөлөөгөөр үүсдэг гэх боловч ихэнх тохиолдолд шалтгааныг тогтооход хэцүү байдаг. Төрөлхийн хөгжлийн гажиг маш олон шалтгаантай ба орчин үед төрөлхийн хөгжлийн гажгийн шалтгааны 50 орчим хувийг тодорхойлж чадахгүй байна. Төрөлхийн хөгжлийн гажгийн шалтгааныг 2 бүлэгт хуваадаг:

1. Удамшлын шалтгаантай
2. Жирэмсэн үед, төрөхөөс өмнө үүсдэг

Төрөлхийн хөгжлийн гажиг, дутуу төрөлт нь олон улс оронд хүүхдийн эндэгдэл, архаг эмгэг, хөгжлийн бэрхшээлтэй болох нэг гол шалтгаан болж байна. Нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс нь төрөлхийн хөгжлийн гажигт шууд бусаар нөлөөлдөг хэдий ч тодорхой нэг гэр бүл, улс оронд илүү өндөр давтамжтай тохиолддог. Бага, дунд орлоготой улс оронд хүнд хэлбэрийн төрөлхийн

хөгжлийн гажгийн 94 орчим хувьд макро, микро тэжээлийн дутагдал, пренаталь үед гажиг үүсгэх хүчин зүйлс ялангуяа халдвар, эхчүүдийн архинд өртөмхий байдал нөлөөлж байна гэжээ.

Эхийн төрөх нас нэмэгдэх тусам хромосомын гажигтай (Дауны хамшинж) хүүхэд төрөх эрсдэл нэмэгддэг байна. Цусан төрлийн гэрлэлт нь зарим цөөн тохиолдолд удамшлын шалтгаант гажгийн шалтгаан болохоос гадна нярайн ба хүүхдийн эндэгдэл, оюуны хомсдол, үеэлүүдийн дунд хүнд гажигтай төрөх эрсдлийг бараг 2 дахин ихэсгэдэг. Зарим Ашкеназийн еврейчүүд, финн зэрэг ястуудын дунд генийн ховор төрлийн мутацийн тархалт өндөр байдаг тул хүнд хэлбэрийн төрөлхийн гажигтай хүүхэд төрөх эрсдэл их байдаг байна. Бага, дунд орлоготой улс орнуудад тэмбүү, улаанууд зэрэг эхийн халдварууд төрөлхийн хөгжлийн гажгийн голлох шалтгаан болж байна.

Эхийн хоол тэжээлийн байдал, иодын дутагдал, фолийн хүчлийн дутагдал, таргалалт, чихрийн шижин зэрэг нь төрөлхийн хөгжлийн гажиг үүсэхэд нөлөөлдөг, тухайлбал, фолийн хүчлийн дутагдал мэдрэлийн гуурсны гажигтай хүүхэд төрөх эрсдлийг нэмэгдүүлдэг. Жирэмсний эрт үедээ эх пестицид, эм, архи, тамхи, бусад сэтгэц нөлөөт эм, химийн бодисын нөлөөнд өртөх, А витаминьг өндөр тунгаар хэрэглэх, цацрагийн өндөр тунд өртөх зэрэг нь ураг, нярайн төрөлхийн хөгжлийн гажигтай болох эрсдлийг ихэсгэдэг. Цаашилбал, хог хаягдал, уурхайд ажиллах, эдгээрийн ойр орчимд амьдрах нь мөн төрөлхийн хөгжлийн гажгийн эрсдэлт хүчин зүйл болдог.

Төрөлхийн хөгжлийн гажиг ихэвчлэн төрөх үед, заримдаа хожуу үед оношилогдож болно. Жишээ нь, бүтцийн гажиг болох нугасны ивэрхийг төрөх үед эмнэлзүйгээр оношилдог бол үйл ажиллагааны гажиг болох гемофилл өвчин хөхүүл, хүүхэд насанд илэрч оношилогддог бол Хатингтоны өвчин насанд хүрсэн хойно оношилогддог байна. Хүнд хэлбэрийн төрөлхийн хөгжлийн гажиг амь насанд аюултайгаас гадна насан туршийн хөгжлийн бэрхшээлтэй болгодог. Оношилгооны чадамж хязгаарлагдмал, эрүүл мэндийн статистикийн мэдээлэл чанаргүй, төрөлхийн хөгжлийн гажгийн тандалт, бүртгэлийн тогтолцоо хөгжөөгүй, хүн амд суурилагаас илүү эмнэлэгт суурилсан судалгаанд түшиглэдэг зэргээс бага, дунд орлоготой орнуудад төрөлхийн хөгжлийн гажгийн талаар мэдээ мэдээлэл хангалтгүй байдаг. 2006 онд эрдэмтдийн (Christianson, Arnold; Howson, Christopher P; Modell, Bernadette, 2006) хийсэн судалгаанаас харахад 2001 онд бүртгэгдсэн гажгуудаас хамгийн түгээмэл тохиолдсон 5 гажгийг дурьдвал:

1. Зүрхний төрөлхийн гажиг
2. Мэдрэлийн гуурсны гажиг
3. Гемоглобины эмгэгүүд, талассеми ба хадуур эст эмгэг
4. Дауны хамшинж (21-р хромосомын гурвал)
5. Глюкоз-6-фосфат дегидрогеназагийн дутагдал зэрэг нь нийт гажгийн 25 орчим хувийг эзэлж байсан.


2010 онд ДЭМБ-ын ассамблей төрөлхийн хөгжлийн гажигтай хүүхдийг эрүүлжүүлэх, анхдагч урьдчилан сэргийлэлтийг дэмжих зорилгоор дараах уриалгыг гаргасан байна. Үүнд:

- Бүртгэл мэдээлэл, тандалтын тогтолцоог хөгжүүлж, бэхжүүлэх
- Мэдлэгийг нэмэгдүүлж, хүчин чадлаа бэхжүүлэх
- Шалтгаан, оношилгоо, урьдчилан сэргийлэлтийн талаар судалж, судалгааг өргөжүүлэх
- Олон улсын хамтын ажиллагааг сайжруулах

Бага, дунд орлоготой орнуудад өндөр орлоготой орнуудыг бодвол төрөлхийн хөгжлийн гажиг үүсгэх хүчин зүйлс их, мөн урьдчилан сэргийлэх арга хэмжээ бага авагдаж байна. Иймд эдгээр орнуудад төрөлхийн хөгжлийн гажгаас урьдчилан сэргийлж, эмчлэхэд удамзүйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх нь чухлаар тавигдаж байна. Төрөлхийн хөгжлийн гажгийн 70 орчим хувь нь урьдчилан сэргийлэх, эмчлэгдэх боломжтой байдаг байна⁴. Төрөлхийн хөгжлийн гажгаас урьдчилан сэргийлэх олон арга байдаг. Жишээ нь, вакцинжуулалтандхамруулах, фолийн хүчил, иодыг зохистой хэрэглэх, жирэмсний хяналтын чанарыг сайжруулах нь урьдчилан сэргийлэх гол арга хэрэгсэлд ордог.

⁴ Global report on birth defects, March of Dimes Birth Defects Foundation, White Plains, New York, 2006


Төрөлхийн хөгжлийн гажгийн урьдчилан сэргийлэлтийн чиглэл




Анхдагч урьдчилан сэргийлэлт



Хоёрдогч урьдчилан сэргийлэлт



Гуравдагч урьдчилан сэргийлэлт



Төрөлхийн хөгжлийн гажиг Монгол улсад: Монгол улсад Мянганы хөгжлийн дөрөвдүгээр зорилтын хүрээндхүүхдийн эндэгдлийг бууруулахын тулд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн нэг шалтгаан болох төрөлхийн хөгжлийн гажгийг эрт оношилох, эмчлэх асуудал чухлаар тавигдаж байна.

Манай оронд нялхсын эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаанд төрөлхийн хөгжлийн гажиг (ТХГ) орохын сацуу сүүлийн 5 жилд нэмэгдэх хандлагатай болов. Тухайлбал, нялхсын эндэгдлийн дотор төрөлхийн хөгжлийн гажгийн эзлэх хувь 2010 онд 12.0% (n=153), 2014 онд 12.7% (n=159) байна.

Манай улсад төрөлхийн хөгжлийн гажгийн бүртгэл мэдээллийн тогтолцоо 2005 оноос хэрэгжиж эхэлсэн хэдий ч улсын хэмжээнд тогтолцоо болон төлөвшиж чадаагүй өнөөг хүрсэн байна. Эрүүл мэндийн сайд (ЭМС)-ын 2014 оны 139 тоот тушаалаар шинээр төрсөн нярай хүүхэд ба нярай үед нь бүртгэж мэдээлэх үйл ажиллагааг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-ийн Тандалт судалгааны алба (ТСА)-хариуцан ажиллах боллоо.

Монгол улсад төрөлхийн хөгжлийн гажиг нь мөн л перинатал эндэгдлийн голлох шалтгаан болж, нялхсын эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаанд багтаж байгаа төдийгүй сүүлийн 5 жилд нэмэгдэх хандлагатай байна. Иймд манай оронд тохиолдох ТХГ-ийн давтамжийг бүс нутгаар тодорхойлох, зонхилон тохиолдох хэлбэр, нөлөөлөх хүчин зүйлсийг судлах шаардлага зайлшгүй тулгарч байна.

Судалгааны зорилго, зорилт: Монгол оронд тохиолдох төрөлхийн хөгжлийн гажгийн давтамж, зонхилон тохиолдох хэлбэр, нөлөөлөх зарим хүчин зүйлсийг тогтоох. Зорилгоо биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаа. Үүнд:

1. Төрөлхийн хөгжлийн гажгийн тохиолдлын давтамжийг нярайн дунд бүс нутгаар тогтоох
2. Зонхилон тохиолдож буй ТХГ-ийн хэлбэрийг тодорхойлох
3. Төрөлхийн хөгжлийн гажиг үүсэхэд нөлөөлөх зарим хүчин зүйлсийг судлах

Судалгааны материал, арга зүй: Судалгааг нэгэн агшны загвараар 2014-2015 онд Монгол улсын 21 аймаг, 384 суманд төрсөн, төрөлхийн хөгжлийн гажиг оношлогдсон бүх тохиолдлыг хамруулан, гүйцэтгэсэн.

Мэдээллийг ЭХЭМҮТ-ийн “Эх, хүүхдийн эрүүл мэндийн тандалт судалгааны тогтолцоо”-г түшиглэн цуглуулсан. Уг тогтолцоо нь Нийслэлийн Амаржих газрууд, 9 дүүргийн Эрүүл мэндийн төв, 21 аймгийн Нэгдсэн эмнэлэгт

оношлогдсон төрөлхийн хөгжлийн гажгийн тохиолдол бүрийг онлайнаар бүртгэдэг тогтолцоо юм.

Судалгаанд дараах шалгуур хангасан тохиолдлыг түүвэрлэлтгүйгээр хамруулсан. Үүнд:

1. Судалгааны хугацаанд шинээр төрсөн, амьдралын эхний 28 хоног дотор амьд өсч торниж байгаа эсвэл эндсэн бүх нярай

2. Өвчний олон улсын ангилал 10-ын 17-р бүлгийн Q бүлэгт орсон бүхий л гажгийн тохиолдол

Судалгааны мэдээлэл цуглуулалтанд Эрүүл мэнд, спортын сайдын 2013 оны 450 тоот тушаалын СТ-11 маягтын асуумжийг ашигласан. Төрөлхийн хөгжлийн гажгийг оношилсон тохиолдолд тухайн нярайн, хүүхдийн эмч 7 хоногийн дотор онлайнаар бүртгүүлж, дэлгэрэнгүй мэдээллийг шаардлагатай тохиолдолд судалгааны баг асууж тодруулав.

Статистик боловсруулалтыг тохиолдлын цуврал, дундаж хэмжигдэхүүн түүний үнэн магадлалыг тодорхойлох Стьюдентийн Т шалгуур, харьцангуй хэмжигдэхүүн түүний үнэн магадлалыг тодорхойлох экстенсив, интенсив арга, нэрэлсэн хэлбэрийн хувьсагчдын хоорондын хамаарлыг шалгах Крамерс В, хувьсагчдын хоорондын хамаарал, хамаарлын хүч, чиглэлийг тодорхойлох Пирсоны корреляци, баримтын, тоон дүрслэлийн судалгааны аргуудыг ашиглан, SPSS-16.0 програмаар боловсруулсан. Судалгаа явуулах зөвшөөрлийг ЭМСЯ-ны дэргэдэх Анагаах ухааны ёс зүйн хорооноос авсан болно.

Судалгааны үр дүн:

Судалгааны хугацаанд (2014 оны 1 сараас 2015 оны 12 сар дуустал) нийт 162590 хүүхэд амьд төрсөн ба төрөлхийн хөгжлийн гажгийн 1364 тохиолдол бүртгэгдсэн нь Монгол улсын хэмжээнд 1000 амьд төрөлтөд 8.4 промил байгаагаас харахад 119 хүүхэд тутмын 1 төрөлхийн хөгжлийн гажигтай төржээ. Энэ нь нийт амьд төрсөн хүүхдийн 0.8 хувийг эзэлдэг гэсэн үг юм.

Улсын хэмжээнд 2014-2015 онд төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайн түвшин хот, хөдөө, орон нутгийн хувьд ялгавартай байгааг Хүснэгт 1-ээр харуулав.

Хүснэгт 1. Амьд төрсөн хүүхэд, төрөлхийн хөгжлийн гажиг, бүртгэгдсэн газар, он, Монгол улс

Аймаг, нийслэл	Амьд төрсөн хүүхэд (N)			Төрөлхийн хөгжлийн гажиг (N)			Төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайн түвшин (1000 амьд төрөлтөд)		
	2014	2015	Нийт	2014	2015	Нийт	2014	2015	Нийт
УЛС	81715	80875	162590	647	717	1364	7.9	8.9	8.4
Баруун бүс	10116	10016	20132	74	47	121	7.3	4.7	6.0
Баян-Өлгий	2789	2770	5559	22	13	35	7.9	4.7	6.3
Говь-Алтай	1265	1293	2558	16	12	28	12.6	9.3	10.9
Завхан	1615	1631	3246	6	6	12	3.7	3.7	3.7
Увс	2127	2009	4136	16	10	26	7.5	5.0	6.3
Ховд	2320	2313	4633	14	6	20	6.0	2.6	4.3
Хангайн бүс	14276	13754	28030	100	96	196	7.0	7.0	7.0
Архангай	2180	2051	4231	10	6	16	4.6	2.9	3.8
Баянхонгор	2183	2133	4316	21	14	35	9.6	6.6	8.1
Булган	1008	991	1999	4	9	13	4.0	9.1	6.5
Орхон	2831	2696	5527	31	40	71	11.0	14.8	12.8
Өвөрхангай	2757	2755	5512	19	18	37	6.9	6.5	6.7
Хөвсгөл	3317	3128	6445	15	9	24	4.5	2.9	3.7
Төвийн бүс	10586	10375	20961	64	55	119	6.0	5.3	5.7
Говьсүмбэр	491	446	937	3	5	8	6.1	11.2	8.5
Дархан-Уул	2855	2644	5499	17	13	30	6.0	4.9	5.5
Дорноговь	1488	1549	3037	15	8	23	10.1	5.2	7.6
Дундговь	948	1001	1949	7	9	16	7.4	9.0	8.2
Өмнөговь	1441	1505	2946	9	3	12	6.2	2.0	4.1
Сэлэнгэ	2029	1956	3985	7	9	16	3.4	4.6	4.0
Төв	1334	1274	2608	6	8	14	4.5	6.3	5.4
Зүүн бүс	4951	4999	9950	36	31	67	7.3	6.2	6.7
Дорнод	1984	1970	3954	22	14	36	11.1	7.1	9.1
Сүхбаатар	1330	1395	2725	6	10	16	4.5	7.2	5.9
Хэнтий	1637	1634	3271	8	7	15	4.9	4.3	4.6
Аймгийн дүн	39929	39144	79073	274	229	503	6.9	5.9	6.4
Улаанбаатар	41786	41731	83517	373	488	861	8.9	11.7	10.3

2014-2015 онд **бүртгэгдсэн** нярайн дунд (1000 амьд төрөлтөд) төрөлхийн хөгжлийн гажигтай нярайн түвшин Орхон (12.8), Говь-Алтай (10.9), Улаанбаатар хот (10.3), Дорнод (9.1) аймагт улсын дунджаас өндөр (Хүснэгт 1) байлаа. Хүснэгт 1-ээс харахад Улаанбаатар хотод 2014-2015 онд төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайн түвшин (10.3) нь **бүртгэгдсэн газраар** авч үзэхэд улсын дунджаас дээгүүр, цаашилбал, 2015 онд Улаанбаатар хотын төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайн түвшин (11.7) 2014 оноос (8.9) 2.8 пунктээр өссөн.

Улсын хэмжээнд 2014-2015 онд төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайн түвшинг **үндсэн харъяалалаар** хүснэгт 2-оос харахад Улаанбаатар

хотод 2014-2015 онд төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайн түвшин (8.0) улсын дунджаас (8.4) доогуур, харин аймагт (8.8) улсын дундаас өндөр байв.


Хүснэгт 2. Амьд төрсөн хүүхэд, төрөлхийн хөгжлийн гажиг, үндсэн харъяалал, он, Монгол улс

Аймаг, нийслэл	Амьд төрсөн хүүхэд (N)			Төрөлхийн хөгжлийн гажиг (N)			Төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайн түвшин (1000 амьд төрөлтөд)		
	2014	2015	Нийт	2014	2015	Нийт	2014	2015	Нийт
УЛС	81715	80875	162590	647	717	1364	7.9	8.9	8.4
Баруун бүс	10116	10016	20132	86	66	152	8.5	6.6	7.6
Баян-Өлгий	2789	2770	5559	25	14	39	9.0	5.1	7.0
Говь-Алтай	1265	1293	2558	16	15	31	12.6	11.6	12.1
Завхан	1615	1631	3246	11	14	25	6.8	8.6	7.7
Увс	2127	2009	4136	19	15	34	8.9	7.5	8.2
Ховд	2320	2313	4633	15	8	23	6.5	3.5	5.0
Хангайн бүс	14276	13754	28030	120	127	247	8.4	9.2	8.8
Архангай	2180	2051	4231	17	10	27	7.8	4.9	6.4
Баянхонгор	2183	2133	4316	22	22	44	10.1	10.3	10.2
Булган	1008	991	1999	10	14	24	9.9	14.1	12.0
Орхон	2831	2696	5527	31	38	69	11.0	14.1	12.5
Өвөрхангай	2757	2755	5512	23	27	50	8.3	9.8	9.1
Хөвсгөл	3317	3128	6445	17	16	33	5.1	5.1	5.1
Төвийн бүс	10586	10375	20961	88	111	199	8.3	10.7	9.5
Говьсүмбэр	491	446	937	5	5	10	10.2	11.2	10.7
Дархан-Уул	2855	2644	5499	18	19	37	6.3	7.2	6.7
Дорноговь	1488	1549	3037	18	17	35	12.1	11.0	11.5
Дундговь	948	1001	1949	10	14	24	10.5	14.0	12.3
Өмнөговь	1441	1505	2946	10	10	20	6.9	6.6	6.8
Сэлэнгэ	2029	1956	3985	13	25	38	6.4	12.8	9.5
Төв	1334	1274	2608	14	21	35	10.5	16.5	13.4
Зүүн бүс	4951	4999	9950	45	49	94	9.1	9.8	9.4
Дорнод	1984	1970	3954	25	23	48	12.6	11.7	12.1
Сүхбаатар	1330	1395	2725	8	16	24	6.0	11.5	8.8
Хэнтий	1637	1634	3271	12	10	22	7.3	6.1	6.7
Аймгийн дүн	39929	39144	79073	339	353	692	8.5	9.0	8.8
Улаанбаатар	41786	41731	83517	308	364	672	7.4	8.7	8.0

2014-2015 онд улсын хэмжээнд төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайн түвшинг улсын дундажтай харьцуулахад **бүртгэгдсэн газраар** 3 аймагт, эхийн **үндсэн харъяаллаар** 11 аймагт улсын дунджаас өндөр, бүс нутгаар авч үзэхэд **үндсэн харъяаллаар** улсын дунджаас Хангай, Төв, Зүүн бүсэд улсын дунджаас өндөр байна (Хүснэгт 1, 2).

Улсын хэмжээнд 2014-2015 онд төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайн түвшинг **бүртгэгдсэн газар, үндсэн харъяалалаар** авч үзэхэд хот, хөдөөд ялгавартай байгааг зураг 1-ээр тодорхой харуулахыг зорилго.

Энэ нь төрөлхийн хөгжлийн гажгийг эрт оношилж Улаанбаатар хот руу илгээн төрүүлдэг (ЭМС-ын 338 тоот тушаал) болсон, бүртгэл мэдээлэл сайжирсантай холбоотой байж болох талтай.




Улс	Аймгийн дундаж	Улаанбаатар хот	Аймгийн дундаж	Улаанбаатар хот
Бүртгэгдсэн газар			Үндсэн харъяалал	


Зураг 3. ТХГ-тай төрсөн нярайн түвшин, бүртгэгдсэн газар, үндсэн харъяалал, 2014-2015 он

Судалгаанд 2014-2015 онд төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайн **бүртгэгдсэн** газрыг эхийн **үндсэн харъяалалтай** харьцуулан дундаж хэмжигдэхүүн түүний үнэн магадлалыг тодорхойлох Стьюдентийн Т шалгуурын аргаар шинжлэхэд статистик ач холбогдлын түвшинд ($p \leq 0.01$) ялгавартай байдал ажиглагдлаа. Тодруулбал, төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайг бүртгэгдсэн газраар авч үзэхэд Улаанбаатар хотод илүүтэй байсан бол эхийн үндсэн харъяаллаар хөдөө, орон нутагт төрөлхийн хөгжлийн гажигтай нярайн түвшин өндөр байгааг хүснэгт 1, 2, зураг 3-т тус тус харууллаа.

Зураг 4. Төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайн түвшин, **бүртгэгдсэн газар**, 2014-2015 он



Зураг 5. Төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайн түвшин, **үндсэн харъяалал**, 2014-2015 он




2014-2015 онд улсын хэмжээнд төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн (n=1364) нярайн өвчний оношийг олон улсын 10 дугаарангиллаар авч үзэхэд 18.8% (n=257) цусны эргэлтийн тогтолцооны гажиг; 17.1% (n=233) яс булчингийн тогтолцооны гажиг; 16.4% (n=224) олон эрхтний хавсарсан гажиг; 15.2% (n=207) сэтэрхий уруул, тагнайн гажиг; 8.6% (n=117) Нүд, чих, нүүр ба хүзүүний төрөлх гажигилүүтэй тохиолдсон байв (Хүснэгт 3).

Хүснэгт 3. ӨОУА-10, төрөлхийн хөгжлийн гажиг, 2014-2015 он, Монгол улс

д/д	Өвчний олон улсын ангилал	Өвчний код	ТХГ-тай төрсөн нярай тоо, хувь		Нийт
			2014	2015	
1	Мэдрэлийн тогтолцооны төрөлх гажиг	Q00-Q07	28 4.3	24 3.3	52 3.8
2	Нүд, чих, нүүр ба хүзүүний төрөлх гажиг	Q10-Q18	60 9.3	57 7.9	117 8.6
3	Цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажиг	Q20-Q28	104 16.1	153 21.3	257 18.8
4	Амьсгалын тогтолцооны төрөлх гажиг	Q30-Q34	3 0.5	8 1.1	11 0.8
5	Сэтэрхий уруул ба тагнай	Q35-Q37	108 16.7	99 13.8	207 15.2
6	Хоол боловсруулах тогтолцооны бусад төрөлх гажиг	Q38-Q45	47 7.3	60 8.4	107 7.8
7	Бэлэг эрхтний төрөлх гажиг	Q50-Q56	16 2.5	18 2.5	34 2.5
8	Шээс ялгаруурах тогтолцооны төрөлх гажиг	Q60-Q64	9 1.4	25 3.5	34 2.5
9	Яс-булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил	Q65-Q79	120 18.5	113 15.8	233 17.1
10	Бусад төрөлх гажиг	Q80-Q89	9 1.4	9 1.3	18 1.3
11	Өөр бүлэгт ангилаагүй хромосомын гажиг	Q90-Q99	35 5.4	33 4.6	68 5.0
12	Олон эрхтний хавсарсан гажиг		106 16.4	118 16.5	224 16.4
13	Бодисын солилцооны удамшлын эмгэг		2 0.3	0 0.0	2 0.1
Бүгд			647 100.0	717 100.0	1364 100.0

Цаашилбал, улсын хэмжээнд 2014 онд төрөлхийн хөгжлийн гажигтай нярайн эмгэгт яс, булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил (18.5%) тэргүүлж байсан бол 2015 онд цусны эргэлтийн тогтолцооны гажиг (21.3%) тэргүүлж, өнгөрсөн оны мөн үеэс 5.2 пунктээр өссөн байлаа (Зураг 6).



Зураг 6. ТХГ-ийн тэргүүлэх шалтгаан, хувиар, 2014-2015 он, Монгол улс

Хүснэгт 4. Төрөлхийн хөгжлийн гажиг, корреляцийн коэффициент (r), 2014-2015 он, Монгол улс

ӨОУА-10	Олон эрхтний хавсарсан гажиг	Бодисын солилцооны удамшлын эмгэг	Өөр бүлэгт ангилаагүй хромосомын гажиг	Бусад төрөлх гажиг	Яс-булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил	Шээс ялгаруурах тогтолцооны төрөлх гажиг	Бэлэг эрхтний төрөлх гажиг	Хоол боловсруулах тогтолцооны бусад төрөлх гажиг	Сэтэрхий уруул ба тагнай	Амьсгалын тогтолцооны төрөлх гажиг	Цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажиг	Нүд, чих, нүүр ба хузүүний төрөлх гажиг	Мэдрэлийн тогтолцооны төрөлх гажиг
Олон хавсарсан эрхтний гажиг	1	0.1**	0.2**	0.2**	0.1**	0.2**	0.2**	0.2**	-0.1	0.2**	0.3**	0.1**	0.1**
Бодисын солилцооны удамшлын эмгэг	0.1**	1.0	0.1*										
Өөр бүлэгт ангилаагүй хромосомын гажиг	0.2**	0.1*	1.0		-0.1			-0.1	-0.1			-0.1	
Бусад төрөлх гажиг	0.2**			1.0									
Яс-булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил	0.1**		-0.1		1.0			-0.1	-0.2		-0.2	-0.1	-0.1
Шээс ялгаруурах тогтолцооны төрөлх гажиг	0.2**					1.0	0.1*	0.1*	-0.1				0.1**
Бэлэг эрхтний төрөлх гажиг	0.2**						1.0		-0.1		-0.1		
Хоол боловсруулах тогтолцооны бусад төрөлх гажиг	0.2**		-0.1		-0.1	0.1*		1.0	-0.1				
Сэтэрхий уруул ба тагнай	-0.1		-0.1		-0.2	-0.1	-0.1	-0.1	1.0		-0.2	-0.1	-0.1
Амьсгалын тогтолцооны төрөлх гажиг	0.2**									1.0			
Цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажиг	0.3**				-0.2		-0.1		-0.2		1.0	-0.1	
Нүд, чих, нүүр ба хузүүний төрөлх гажиг	0.1**		-0.1		-0.1				-0.1		-0.1	1.0	
Мэдрэлийн тогтолцооны төрөлх гажиг	0.1**				-0.1	0.1**			-0.1		-0.1		1.0

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

* . Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

2014-2015 онд улсын хэмжээнд төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярайд тохиолдсон олон эрхтний гажиг бүхий хувьсагчийг нярай тус бүрт тохиолдсон гаж хөгжлийн давтамжтай хамааралтай эсэхийг Пирсоны корреляцийн аргаар шинжлэхэд өөр хоорондоо шууд, шууд бус ($r=0.1$, $r=0.2$, $r=0.3$ $p \leq 0.01$, $p \leq 0.05$) хамааралтай байв (Хүснэгт 4). Хүснэгт 4-өөс харахад олон

эрхтний хавсарсан гажиг нь цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажигтай шууд, дунд зэрэг ($r=0.3$ $p\leq 0.01$), хромосомын, бусад төрөлх гажиг, шээс ялгаруулах, бэлэг эрхтний, хоол боловсруулах тогтолцооны, амьсгалын тогтолцооны төрөлх гажигтай шууд, сул ($r=0.2$ $p\leq 0.01$) хамааралтай болох нь судалгааны дүнд тогтоогдлоо.

2014-2015 оныолон эрхтний хавсарсан гажгийг эрхтэн тогтолцооны эмгэг тус бүрт оруулан задалж, гүнзгийрүүлэн шинжлэхэд 28.7% ($n=392$) цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажиг; 23.7% ($n=323$) яс булчингийн тогтолцооны гажиг; 17.6% ($n=240$) сэтэрхий уруул, тагнайн гажигилүүтэй тохиолдсон байлаа (Хүснэгт 7).

Хүснэгт 5. Нярайн ТХГ-ийн дан, хавсарсан хэлбэр, өвчлөлийн бүтэц, 2014 он, Монгол улс

д/д	Өвчний олон улсын ангилал	Дан ($n=647$)	Олон эрхтний хавсарсан гажиг ($n=106$)	Бүгд*** ($n=647$)	
				тоо	хувь
1	Цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажиг	104	57	161	24.9
2	Яс-булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил	120	42	162	25.0
3	Сэтэрхий уруул ба тагнай	108	24	132	20.4
4	Нүд, чих, нүүр ба хүзүүний төрөлх гажиг	60	19	79	12.2
5	Хоол боловсруулах тогтолцооны бусад төрөлх гажиг	47	31	78	12.1
6	Өөр бүлэгт ангилаагүй хромосомын гажиг	35	20	55	8.5
7	Мэдрэлийн тогтолцооны төрөлх гажиг	28	17	45	7.0
8	Шээс ялгаруурах тогтолцооны төрөлх гажиг	9	21	30	4.6
9	Бэлэг эрхтний төрөлх гажиг	16	13	29	4.5
10	Бусад төрөлх гажиг	9	18	27	4.2
11	Амьсгалын тогтолцооны төрөлх гажиг	3	15	18	2.8
12	Бодисын солилцооны удамшлын эмгэг	2	1	3	0.5
13	Олон эрхтний хавсарсан гажиг	106	-	-	-

Хүснэгт 6. Нярайн ТХГ-ийн дан, хавсарсан хэлбэр, өвчлөлийн бүтэц, 2015 он, Монгол улс

д/д	Өвчний олон улсын ангилал	Дан ($n=717$)	Олон эрхтний хавсарсан гажиг ($n=118$)	Бүгд*** ($n=717$)	
				тоо	хувь
1	Цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажиг	153	78	231	32.2

2	Яс-булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил	113	48	161	22.5
3	Сэтэрхий уруул ба тагнай	99	9	108	15.1
4	Нүд, чих, нүүр ба хүзүүний төрөлх гажиг	57	26	83	11.6
5	Хоол боловсруулах тогтолцооны бусад төрөлх гажиг	60	37	97	13.5
6	Өөр бүлэгт ангилаагүй хромосомын гажиг	33	29	62	8.6
7	Мэдрэлийн тогтолцооны төрөлх гажиг	24	10	34	4.7
8	Шээс ялгаруурах тогтолцооны төрөлх гажиг	25	18	43	6.0
9	Бэлэг эрхтний төрөлх гажиг	18	17	35	4.9
10	Бусад төрөлх гажиг	9	11	20	2.8
11	Амьсгалын тогтолцооны төрөлх гажиг	8	8	16	2.2
12	Бодисын солилцооны удамшлын эмгэг	0	3	3	0.4
13	Олон эрхтний хавсарсан гажиг	118	-	-	-

Хүснэгт 7. Нярайн ТХГ-ийн дан, хавсарсан хэлбэр, өвчлөлийн бүтэц, 2014-2015 он, Монгол улс

д/д	Өвчний олон улсын ангилал	Дан (n=1364)	Олон эрхтний хавсарсан гажиг (n=224)	Бүгд*** (n=1364)	
				тоо	хувь
1	Цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажиг	257	135	392	28.7
2	Яс-булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил	233	90	323	23.7
3	Сэтэрхий уруул ба тагнай	207	33	240	17.6
4	Нүд, чих, нүүр ба хүзүүний төрөлх гажиг	117	45	162	11.9
5	Хоол боловсруулах тогтолцооны бусад төрөлх гажиг	107	68	175	12.8
6	Өөр бүлэгт ангилаагүй хромосомын гажиг	68	49	117	8.6
7	Мэдрэлийн тогтолцооны төрөлх гажиг	52	27	79	5.8
8	Шээс ялгаруурах тогтолцооны төрөлх гажиг	34	39	73	5.4
9	Бэлэг эрхтний төрөлх гажиг	34	30	64	4.7
10	Бусад төрөлх гажиг	18	29	47	3.4
11	Амьсгалын тогтолцооны төрөлх гажиг	11	23	34	2.5
12	Бодисын солилцооны удамшлын эмгэг	2	4	6	0.4
13	Олон эрхтний хавсарсан гажиг	224	-	-	-

Хүснэгт 8. ТХГ-ийн өвчлөлийн бүтэц, 2014 он, Монгол улс

№	Өвчний олон улсын ангилал	Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-Алтай	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Сэлэнгэ	Төв	Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Дархан-Уул	Орхон	Говьсүмбэр	Улаанбаатар	Улс
1	Мэдрэлийн тогтолцооны төрөлх гажиг		1 4.5	1 4.8							1 5.3						1 7.1				3 9.7		21 5.6	28 4.3
2	Нүд, чих, нүүр ба хүзүүний төрөлх гажиг	2 20.0	3 13.6				1 6.7	1 4.5			1 5.3	1 11.1	1 16.7	1 14.3	2 33.3	2 12.5		1 6.7			3 9.7		41 11.0	60 9.3
3	Цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажиг		3 13.6	1 4.8		2 12.5	6 40.0	6 27.3		1 16.7	1 5.3			2 28.6		5 31.3	1 7.1	3 20.0	2 25.0	4 23.5	12 38.7	1 33.3	54 14.5	104 16.1
